



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар

А/61

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/214 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийтийн байрны орчин, нөхцөлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, нийтээр дагаж мөрдөх хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг сурталчлан таниулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, явц, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Дэд ажлын хэсэг (Ж.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухай бүр дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Цэрэннамжил)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1507010001

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны
62 дугаар сарын 18-ны өдрийн 161 дүгээр
захирамжийн хавсралт



Дэд ажлын хэсгийн

ахлагч: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Дэд ажлын хэсгийн

гишүүд:

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын Улсын ахлах байцаагч, байцаагч, барилгын хяналт хариуцсан ахлах инженер, барилгын хяналт хариуцсан ажилтан

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дотоод хяналт, шинжилгээний хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн авто тээврийн хяналтын Улсын ахлах байцаагч

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн Чингэлтэй дүүрэг хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын холбогдох албан тушаалтнууд

Дүүргийн менежер

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төхижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Дүүргийн Цагдаагийн газрын дарга

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга

Дүүргийн Татварын хэлтсийн дарга

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга

Дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар

Дэд ажлын хэсгийн

нарийн бичгийн

дарга:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга